

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Увс аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2022/184/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаангом хот 2022 он</p>	<p>Увс аймаг дахь Төрийн аудитын газар, Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn Аудитын менежер: М.Бат-Амгалан Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn Аудитор: А.Нанжидмаа Утас: 70453799, Цахим хаяг: Nanjidmaaa@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
3. Аудитын тайлан	8
3.1 Ерөнхий зүйл	8
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	8
3.4 Материаллаг байдал.....	9
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	9
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	9
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	11
3.8 Аудитын гол асуудал.....	11
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	11
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	12
4. Аудитын илрүүлэлт.....	12
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	12

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

АЙМГИЙН ХӨДӨЛМӨР,
ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ГАЗРЫН ДАРГА Д.ЦОГТ-ОЧИР
ТАНАА

2022.02.25 № УВА-2022/184/НА-СТА-ТНЗ
танай _____-ны № _____-т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Увс аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

0200200576

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,996,231,400.0	1,768,248,903.0
33	АВЛАГА	1,996,231,400.0	1,768,248,903.0
33700	Хөтөлбөртэй холбоотой авлага	1,957,094,400.0	1,749,323,903.0
33703	Хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл хоршоо байгуулах иргэнийг дэмжих	729,451,900.0	738,743,900.0
03370 5	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	160,146,000.0	178,077,003.0
33706	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	783,718,500.0	584,833,000.0
33717	Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	69,720,000.0	84,565,000.0
33718	Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнес дэмжих	214,058,000.0	163,105,000.0
33300	Татаас, санхүүжилтийн авлага	39,137,000.0	18,925,000.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,996,231,400.0	1,768,248,903.0
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	50,053,690.0	0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	50,053,690.0	0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,946,177,710.0	1,768,248,903.0
51	Засгийн газрын хувь оролцоо	1,946,177,710.0	1,768,248,300.0
51200	Хуримтлагдсан үр дүн	1,946,177,710.0	1,768,248,903.0
51210	Өмнөх үеийн үр дүн	1,946,177,710.0	1,946,177,710.0
51220	Тайлант үеийн үр дүн	0	(177,928,807).0
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,996,231,400.0	1,768,248,903.0

2.2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	774,089,500.0	773,073,200.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	774,089,500.0	773,073,200.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	408,811,000.0	773,073,200.0
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандав, тусламж	6,811,000.0	30,007,800.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	402,000,000.0	743,065,400.0
1350	Засгийн газрын тусгай сан	365,278,500.0	
13503	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	365,278,500.0	
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	575,165,190.0	951,002,007.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	575,165,190.0	951,002,007.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,195,500.0	34,555,950.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,995,500.0	7,048,150.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,995,500.0	5,548,150.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		1,500,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,200,000.0	27,507,800.0
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	1,200,000.0	27,507,800.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	570,969,690.0	916,446,057.0
2134	Орон нутгийн төсвөөс ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	17,394,000.0	1,500,000.0
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,500.0	1,500,000.0
213405	Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг	17,389,500.0	49,338,450.0
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	311,210,000.0	568,482,497.0
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	311,210,000.0	568,482,497.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	242,365,690.0	297,125,110.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	242,365,690.0	297,125,110.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	198,924,310.0	(177,928,807.0)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	198,924,310.0	(177,928,807.0)

2.3. АУДИТ ХИЙСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл				
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт				
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт				
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
7	Өмчид гарсан өөрчлөлт				
8	Зарласан ногдол ашиг				
9	Тайлант үеийн үр дүн				
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			1,946,177,710	1,946,177,710
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл			1,946,177,710	1,946,177,710
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт				
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт				
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
17	Өмчид гарсан өөрчлөлт				
18	Зарласан ногдол ашиг				
19	Тайлант үеийн үр дүн			(177,928,807)	(177,928,807)
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл			1,768,248,903	1,768,248,903

2.4.АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,093,239,500.0	1,322,843,697.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	319,150,000.0	549,770,497.0
1200	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	319,150,000.0	549,770,497.0
12004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	319,150,000.0	549,770,497.0
120041	Үндсэн үйл ажиллагааны орлого	319,150,000.0	549,770,497.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	774,089,500.0	773,073,200.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	408,811,000.0	773,073,200.0
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	6,811,000.0	30,007,800.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	402,000,000.0	743,065,400.0
1350	Засгийн газрын тусгай зориулалтын сангаас санхүүжих	365,278,500.0	0
13503	Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих	365,278,500.0	0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,093,239,500.0	1,322,843,697.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,093,239,500.0	1,322,843,697.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,195,500.0	34,555,950.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,995,500.0	7,048,150.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,995,500.0	5,548,150.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		1,500,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,200,000.0	27,507,800.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,200,000.0	27,507,800.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,089,044,000.0	1,288,287,747.0
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	6,188,000.0	0
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,500.0	0
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	18,889,500.0	0
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	319,150,000.0	580,183,947.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	744,812,000.0	689,178,800.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	744,812,000.0	689,178,800.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	0	0
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	0	0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0	0
2200	Дотоод эх үүсвэрээр	0	0
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0	0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	0	0
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0	0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0	0
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	0

2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		530,845,497.0		
0000	Төрийн сан		530,845,497.0		
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг		530,845,497.0		
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		530,845,497.0		
120	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС		530,845,497.0		
120004	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		530,845,497.0		

2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	760,775,400.0	723,734,750.0	37,040,650.0	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	760,775,400.0	723,735,750.0	37,040,650.0	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	22,258,150.0	34,555,950.0	-12,297,800.0	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,048,150.0	7,048,150.0	0	
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,548,150.0	5,548,150.0	0	
210802	Аудит, баталгаажуулалт	1,500,000.0	1,500,000.0	0	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,210,000.0	27,507,800.0	-12,298,800	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	15,210,000.0	27,507,800.0	-12,298,800	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	738,517,250.0	689,178,800.0	49,338,450.0	
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг			49,338,450.0	
2132	Бусад урсгал шилжүүлэг	738,517,250.0	689,178,800.0	49,338,450.0	
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	738,517,250.0	689,178,800.0	49,338,450.0	
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	760,775,400.0	773,073,200.0	-12,297,800.0	
31	Нэмэлт санхүүжилтийн орлого	760,775,400.0	773,073,200.0	-12,297,800.0	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	743,065,400.0	743,065,400.0	0	
131105	Гадаад улс, олон улсын байгууллагын зээл тусламж	17,710,000.0	30,007,800.0	-12,297,800.0	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Увс аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор А.Нанжидмаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Увс аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 34 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь “Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, иргэдэд нийгмийн халамжийн үйлчилгээг чанартай, үр дүнтэй, шуурхай хүргэх замаар нийгмийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэгдсэн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний төрийн бодлогыг харьяалах нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх” эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг төсвийн тухай хуульд өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын хэлтэс эрсдэлд суурилсан дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Увс аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 951.0 сая төгрөгөөс 1 хувиар буюу 9.5 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 7.6 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Увс аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 86,857.9 мянган төгрөгөөр буюу 12.3 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	1,996,231.4	1,768,248.9	-227.982.5
Бараа материал	0	0	0
Үндсэн хөрөнгө	0	0	0
Нийт хөрөнгө	1,996,231.4	1,768,248.9	-227.982.5
Өр төлбөр	50.0	0	-50.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,946,177.7	1,768,248.9	-177928.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,996,231.4	1,768,248.9	227.982.5

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,768,248.9 мянган төгрөг болж 227,982.4 мянган төгрөгөөр буурсан нь авлага буурснаас шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл 50,053.9 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны үлдэгдлээ бүрэн барагдуулснаас шалтгаалжээ.

Нийт зардал өмнөх оноос 25,273.1 мянган төгрөгөөр буюу 3.3 хувиар буурсан байна. Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн ажил олгогчийн урамшуулал, түрээсийн хөнгөлөлтийн гэрээ 2020 онд хийгдээгүй байсантай холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус сангийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,137,695.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 2,137,695.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 1,361,807.8 мянган төгрөгөөр бууруулж 775,887.2 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь 2021 онд улсын төсвөөс санхүүжилт аваагүйтэй холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 549,770.4 мянган төгрөг бүрдүүлж, зээлийн эргэн төлөлт 530,845.4 мянган төгрөгийн төв санд шилжүүлж, 18,925.0 мянган төгрөгийг сангийн яам татаж авсныг авлагаар тусгасан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 6 хөтөлбөрийн 15 арга хэмжээ, 2 үйлчилгээ болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг санхүүжүүлэхээр 743,065.4 мянга, дэлхийн банкны санхүүжилтээр 17,710.0 мянга, Швейцарийн хөгжлийн агентлагийн санхүүжилттэй залуучуудын хөдөлмөр

эрхлэлтийг дэмжих төслөөс 12,297.8 мянган төгрөг нийт 773,073.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Үүнээс бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 5,548.1 мянга, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх 27,507.8 мянга, аудит баталгаажуулалт, зэрэглэл тогтоох 1,500.0 мянга, Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал 689,178.8 мянган төгрөг зарцуулж, 49,338.4 мянган төгрөгийн төвлөрүүлжээ.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 706.1-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан ерөнхий чиглэлийн дагуу Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх онд зөвлөмж, албан шаардлага өгсөн болон эрсдэл бүхий байгууллагыг түүвэрт хамруулан шалгасан. Увс аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хувьд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй байсан тул Шилэн дансны үйл ажиллагаа, мэдээлэлд хийх нийцлийн аудитаар шалгахаар шийдвэрлэв.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 147 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан, байршуулах хугацаа болоогүй 2, хугацаа хоцроож мэдээлсэн 2 мэдээлэл байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчилтэй асуудал байхгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 513,420.4 мянган алдаа зөрчил илэрснээс, 511,920.4 мянган төгрөгийн алдааг залруулж, 1,500.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүллээ.

4.1 Залруулсан алдаа

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтад “Үнэн зөв байх” гэж заасныг зөрчин 511,920.4 мянган төгрөгийн нэр данс зөрүү орлогыг төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгасныг аудитын явцад залруулав.

4.3 Албан шаардлага

Увс аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан 1,500.0 мянган төгрөгийн 3 гүйлгээг төсвийн эдийн засгийн ангилал зөрчиж гүйлгээ хийсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтад “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, тухайн үед мөрдөгдөж байсан Сангийн сайдын 2014 оны 55 дугаар “Эдийн засгийн ангилал батлах тухай” тушаалын 06 дугаар хавсралтад заасан эдийн засгийн ангиллыг зөрчиж байна. Иймд дээрх алдаа зөрчилд зөрчил давтан гаргахгүй байхыг албан шаардлага болголоо.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	2	513.4	1	511.9			1	1.5		

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.


АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  /М.БАТЦСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР  /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН: АУДИТОР

 /А.НАНЖИДМАА/

2022 оны 02 сарын 19-ний өдөр